



Д.БАТГЭРЭЛ

**Хорих 401 дүгээр
ангийн ерөнхий жижүүр,
ахмад**

ЯЛТНЫ ХӨДӨЛМӨРИЙГ ГАДААДЫН ЗАРИМ ОРОНД ЗОХИОН БАЙГУУЛЖ БҮЙ ПРАКТИК

Ялтныг засан хүмүүжүүлэх тэднийг ял эдлээд гарсны дараах чөлөөт амьдралд бэлтгэхэд ялтны хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловрол олгох болон чөлөөт цагийг зохицтой ашиглах зэрэг ажлыг зөв зохион байгуулах явдал чухал. Албан хүчээр бий болсон хэт их чөлөөт цагийг өнгөрөөх нь ялтнуудын хувьд болон ял эдлүүлэх байгууллагын хувьд маш хүнд асуудал юм. Ял эдлэх хугацаа ялтны цагийг үр ашигтай ашиглахад дараах гурван хүчин зүйл гол Үүрэгтэй.

- Ялтны үр ашигтай хөдөлмөрөөр хангах

- Хорих байгууллагын дэргэд ерөнхий болон мэргэжлийн боловсрол олгох боломжийг бүрдүүлж, боловсрол олгохийг хүссэн ялтнуудыг сургах

- Чөлөөт цагийг үр ашигтай өнгөрөөх ажлыг зохион Ялтнуудын байгуулах олон нийт, шашин, урлагийн зэрэг үйл ажиллагаанд оролцох нөхцөлийг бүрдүүлэх зэрэг болно.

Эдгээрээс хамгийн гол нь ялтны хөдөлмөр эрхлэлт юм. Ялтны хөдөлмөр эрхлэлтийн талаар улс бүр ялгаатай ханддаг байна. Жишээлбэл: ОХУ нь Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх хуулиар бүх ялтан албадан хөдөлмөр хийх ёстой байдаг бол Европын орнууд АНУ, Япон зэрэг улсуудад хоригдлын хөдөлмөр бол албадан хөдөлмөр гэсэн логикоор

ханддаг байна. Олон улсын эрх зүйн нормоор ялтны албадан хөдөлмөрийг тодорхой нөхцөлтэйгээр байж болохыг үгүйсгэдэггүй. Тухайлбал ялтны эрхлэх хөдөлмөр нь түүний мэргэжил чадварыг тоочсон байх ёстой. Хэрэв ингэх бололцоогүй бол уг хөдөлмөр нь ашигтай бөгөөд нийгмийн ач холбогдолтой байх ёстой гэх мэт төрөл бүрийн нөхцөл байна. Харин улсуудын хуулийн практикт бол ихээхэн ялгаатай байна. Зарим улсуудад албан хөдөлмөрийг хуулиараа зөвшөөрдөг бол зарим улсад тэдний хөдөлмөрийг хөдөлмөрийн эрх чөлөөний зарчимд нийцэх ёстой гэж үздэг. Хөдөлмөр эрхлэхтэй холбоотой эрүүгийн гэмт хэргийн шийтгэл нь албадан хөдөлмөрлүүлэх ба шоронд хориод албадан хөдөлмөр эрхлүүлэх гэж 2 хуваагдана. Мөн хөдөлмөр эрхлүүлэхээр эрүүгийн шийтгэл оноогоод шорон аюулгүй хөдөлмөрлөхөд ашиглах болон ялтныг ялын хугацаандаа ямарваа нэгэн зүйл эрхэлсэн байлгахын тулд хөдөлмөрлүүлэх / албадан хөдөлмөр биш / гэж ангилах ч бий. Энэ ангилалыг тодруулбал:

- Шоронгийн албадан хөдөлмөр. Энэ нь чөлөөт бус хөдөлмөрийн нэг хэлбэр бөгөөд шоронд хорих ял дээр нэмэлт шийтгэл маягаар эртнээс хэрэглэж ирсэн, одоо ч ОХУ гэх мэт зарим оронд хэрэглэсээр байгаа шийтгэл юм. Ийм хөдөлмөр нь тодорхой үр дүн бүхий үйлдвэрлэлийн Юуны өмнө ялтан үр ашигтай хөдөлмөр эрхэлж, тодорхой хэмжээний мөнгөн хуримтлалтай болох нь эргэн нийгэмшихэд нь чухал Үүрэгтэй. Ялтан чөлөөлөгдсөнийхөө дараа ажил олоход нь тус болох чадвар эзэмших боломжтой.

- Мөн засан хүмүүжүүлэх маш чухал ач холбогдолтой. Шоронгийн ялтны амьдралын харгис хатуу нэгэн төрлийн уйтгартай байдлыг нь зөөллөнө. Ажил хөдөлмөр эрхлэн завгүй байснаар ялтан ямарваа нэгэн хүчирхийлэлийн юмуу нийгмийн эсрэг үйл ажиллагаанд татагдан орохгүй байх талтай. Суугаа амьдралаар

байнга байхгүй нь тэдний эрүүл мэндэд ч зохих нөлөөтэй.

I. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

АНУ-д ялтны хөдөлмөр эрхлэх асуудлыг 1973 оны 11755 / 1987 онд 12608 дугаар хулийн дэд актаар нэмэлт оруулсан/, 1994 оны 12943 дугаар хуулийн дэд актуудаар зохицуулсан байдаг. Эдгээр актанд “Ялтнуудын мэргэжлийн болон боловсролын чадварыг хөгжүүлэх нь тэдний засран хүмүүжих болон эргээд чөлөөт нийгэмд очиж амьдрахад нь зайлшгүй чухал шаардлагатай. Учир утгатай хөдөлмөр эрхлэлт тэдний эдгээр чадварыг хөгжүүлэх ач холбогдолтой. Гэхдээ хоригдлуудын хөдөлмөрийг мөлжих болон бараа таваар үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх зэрэгт хоригдлуудын хөдөлмөр ба чөлөөт хөдөлмөрийн хооронд эрүүл бус өрсөлдөөн үүсэхээс сэргийлэн болгоомжтойгоор зохион байгуулах ёстой” гэж заасан байна. Энэ хуулийн дэд актаар ажил олгогч доор дурьдсан этгээдүүдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулахыг хориглоогүй. Үүнд:

1. Хугацаанаас өмнө суллагдсан болон туршилтын хугацаанд байгаа этгээд
2. Өршөөгдсөн болон хугацаат ялаа эдлээд гарсан этгээд
3. Холбооны шоронд ял эдлэгч
4. Холбооны биш шоронд ял эдлэгч зэрэг хүмүүс цалин хөлстэй хөдөлмөр эрхлэхийг хуулийн дэд актанд заасан дор дурьдсан хууль эрхийн орчинд зөвшөөрнө. Үүнд:
 - a) Ажиллагч хөдөлмөрийн хөлс авдаг юмуу батлагдсан хөдөлмөрийн сургалтанд сайн дурын үндсэн дээр хамрагдах
 - b) Үйлдвэрчний төв байгууллагын тухайн нутаг дахь төлөөлөгч юмуу адил төстэй үйлдвэрчний байгууллагатай зөвшилцсөн
 - c) Хөдөлмөрийн хөлс төлөх ажил нь а. Хөлсний ажилчдыг өөр газар руу аваачихгүй байх, б. Тухайн нутагт илүүдэлтэй байгаа үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээнд

оролцохгүй байх болон, в. Үйлчилгээний ажлын гэрээг дордуулахгүй байх.

d) Хөдөлмөрийн хөлс болон хөдөлмөрийн бусад нөхцөл нь тухайн орон нутаг дахь адил төстэй хөдөлмөрийнхөөс доошгүй байх.

e) Ажил эрхлэхтэй холбоотой хуулиуд болон бусад зохицуулах дүрэм журам нь 11755 дугаар хуулийн дэд акт ба түүнд оруулсан нэмэлтүүдийн шаардлагад нийцсэн байна гэдгийг АНУ-ын Ерөнхий прокурор батласан байх.

Federal Prison Industries, Inc., буюу UNICOR нэрээр нийтэд танигдсан байгууллага нь 1934 онд холбогдох хууль тогтоомж болон Executive Order-ийн дагуу байгууллагдсан төрийн өмчит корпораци бөгөөд Холбооны шоронгийн товчооны ялтнуудын хөдөлмөрийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлдэг юм. Executive order гэдэг нь АНУ-ын ерөнхийлөгч холбооны гүйцэтгэх засгийн тэргүүний хувьд гаргадаг зарлиг юм. Executive order нь гүйцэтгэх засгийн албан хаагчдын хэрэгжүүлэн ажиллах журмыг тогтоох бөгөөд иргэдэд ямар нэг үүрэг оноохгүй. АНУ-ын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн хэсэгт Төлөөлөгчдийн танхим ба сенатаас бүрдэх Нэгдсэн улсын Конгресс энд тогтоосон хууль тогтоох бүрэн эрхийг эдэлнэ” гэж заасан байдаг. Конгрессоос гаргасан хуулийн актаар ерөнхийлөгчид шилжүүлсэн бүрэн эрхийн хүрээнд тодорхой хуулийг хэрэгжүүлэхийн тулд гаргасан Executive order нь хуулийн бүрэн чадамжтай байна.

Уг корпорацийн гол зорилго нь ялтнуудад ажил олгох, мэргэжлийн дадлага олон бэлтгэх, ялтнуудыг ажилтай байлгаснаар засан хүмүүжүүлэх байгууллагуудын аюулгүй байдлыг хангах, зах зээлийн үнээр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бие даан ажиллах юм. UNICOR нь ялтныг хөдөлмөр хийлгэхээр албадаж болохгүй бөгөөд хөдөлмөр эрхлэх эсэх нь зөвхөн сайн дурын үндсэн дээр байна. Мэргэжлийн бэлтгэл хийлгэхэд ч мөн адил.

Ажлын сайн чадвар эзэмшсэн, сайн ажилласан ялтанд шоронгоос гараад нь UNICOR –ийн зүгээс дэмжлэг үзүүлдэг. UNICOR нь бүтээгдэхүүн үйлчилгээгээ зөвхөн холбооны засгийн газрын байгууллагуудад зарах бөгөөд шууд зах зээлд гарах эрхгүй. UNICOR нь холбооны шоронгуудад 109 үйлдвартай, 175 орчим бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлдэг байсан байна. UNICOR нь эдийн засгийн хувьд бүрэн бие даасан байгууллага бөгөөд улсаас ямар нэгэн санхүүжилт авдаггүй. Ялтнуудын хөдөлмөрөөр бүтсэн бүтээгдэхүүнийг Холбооны засгийн газрын байгууллагууд худалдан авахдаа Холбооны худалдан авалтыг зохицуулах системийн журмыг баримтлана.

2. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС.

Ялтныг хөдөлмөр эрхлүүлэх асуудлыг Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Тахир дутуу хүний нийгэм хамгааллын тухай хуулиар тус тус зохицуулдаг байна.

ОХУ-ын Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийн 14-р бүлэгт Хорих ял эдэлж буй ялтнуудыг хөдөлмөр, мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтанд хамруулах талаар зохицуулалтуудыг заасан байна.

103 дугаар зүйл. Ялтныг хөдөлмөр эрхлүүлэх

1. Бүх ялтнууд хоригдож байх хугацаанд засан хүмүүжүүлэх байгууллагын захиргаанаас тодорхойлсон ажлын байранд хөдөлмөр эрхлэх үүрэгтэй. Засан хүмүүжүүлэх байгууллагын захиргаа нь ялтнуудын нас хүйс, хөдөлмөр эрхлэх чадвар, эрүүл мэндийн байдал, ажлын байрнаас хамаарч тэднийг хөдөлмөр эрхлүүлэх үүрэгтэй.
2. 60-аас дээш насын эрэгтэй, 55-аас дээш насын эмэгтэй мөн тахир дутуугийн 1,2 дугаар групптэй ялтнуудыг өөрсдийнх нь

хүсэлтээр холбогдох хууль тогтоомжийн дагуу хөдөлмөр эрхлүүлнэ. / Хөдөлмөрийн хууль, Тахир дутуу хүний нийгэм хамгааллын тухай /

Насанд хүрээгүй ялтнуудыг мөн ОХУ-ын хөдөлмөрийн хуульд заасны дагуу хөдөлмөр эрхлүүлнэ.

3. Шоронд хорих ял эдэлж буй ялтнуудыг энэ хуулийн 74-р зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу шоронгийн газар нутаг дээр хөдөлмөрлүүлнэ.
4. Хоригдлуудын ажиллахыг хориглох ажлын жагсаалтыг засан хүмүүжүүлэх байгууллагын дотоод журмаар тогтооно.
5. Хоригдлуудын хөдөлмөрлөх цаг нь засан хүмүүжүүлэх байгууллагын үндсэн зорилт болох засан хүмүүжүүлэх үйл ажиллагаатай давхцаж болохгүй.
6. Ажлаас татгалзах, эсвэл ажлыг зогсоовол тогтоосон журмыг санаатай зөрчсөн гэж үзэж шийтгэлийн арга хэмжээ, хариуцлага хүлээлгэнэ.

104 дүгээр зүйл Ялтнуудын хөдөлмөрийн нөхцөл

1. Ялтны ажиллах хугацаанд хөдөлмөр хамгааллын, техникийн аюулгүй байдал болон ариун цвэрт холбогдох дүрмийг ОХУ-ын хөдөлмөрийн тухай хууль тогтоомжинд нийцүүлэн тогтооно. Ажлын эхлэх болон дуусах цаг нь ээлжийн графикаар тодорхойлогдоно.
2. Засан хүмүүжүүлэх болон шоронд ял эдэлж буй хоригдлуудын гүйцэтгэж байгаа ажлууд нь ажлын цагийг уртгасан хэлбэрт ордог. / Өдөр болгон тогтмол цагаар ажилладаггүй. Нэг өнжөөд 24 цаг цаг ч юм уу ажилладаг гэсэн утгатай/
3. Ялтнуудын цалинтай ажил хийлгэхэд цаг нь нийт ажлын цагаар тооцогдоно. Засан хүмүүжүүлэх байрны захиргаа нь ажлын цагийг тооцож гаргана. Хэрэв ажил гүйцэтгэхээс байнга зайлсхийвэл, засан хүмүүжүүлэх байгууллагын захиргааны шийдвэрээр ялтны нийт ажлын цагаас хасна. Засан хүмүүжүүлэх байгууллагын шийдвэр нь шүүхэд гомдол болон очиж болно.

4. Ажил хийдэг хоригдлууд жил бүр төлбөртэй амралт авна. Хүмүүжүүлэх колонид хорих ял эдэлж буй ялтан ажлын 18 өдөр, засан хүмүүжүүлэх байгууллагад хоригдож буй ялтан 12 ажлын өдрийн амралт / төлбөртэй / авах эрхтэй.

108 дугаар зүйл

1. Мэргэжилгүй ялтнуудад анхан шатны мэргэжлийн боловсрол, мэргэжлийн бэлтгэл олгох ажлыг засан хүмүүжүүлэх газар зохион байгуулна. Мэргэжил эзэмшсэн ялтнууд засан хүмүүжүүлэх байранд болон суллагдсаныхаа дараа ч тэндээ ажиллаж болно.

2. Тахир дутуугийн 1, 2 дугаар группт байдаг ялтнууд 60-аас дээш насын эрэгтэй мөн 55-аас дээш насын эмэгтэй ялтнуудыг өөрсдийнх нь хүсэлтээр холбогдох мэргэжлийн сургалтанд хамрагдуулж болно.

3. Ялтнуудыг анхан шатны мэргэжлийн боловролын сургалтанд хамруулахдаа тэдний хүмүүжиж буй зэргийг харгалзан үзнэ.

4. Анхан шатны мэргэжлийн боловсрол олгох мэргэжлийн сургалт зохион байгуулах ажлыг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас тогтоосон журмын дагуу явуулна. Засан хүмүүжүүлэх байгууллага нь ялтнуудын дээд мэргэжлийн боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

5. Бүх насаараа хоригдож буй ялтнууд шууд үйлдвэр дээр мэргэжил эзэмшинэ.

3. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

БНСУ -ын хорихын байгууллагуудыг Хууль зүйн яам мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилладаг. БНСУ-ын Эрүүгийн хуулийн 3-р бүлэгт ял шийтгэлийн талаар хуульчилсан байдаг. Хуулийн 41-р зүйлд дараах ял шийтгэлийн төрлүүдийг хуульчилсан байна. Үүнд:

1. Цаазаар авах
2. Хорих
3. Ажил хөдөлмөр хийлгэхгүйгээр хорих

4. Зэрэг дэв хасах
5. Мэргэжлийн зэрэг хасах
6. Торгууль
7. Албадан саатуулах буюу баривчлах
8. Бага хэмжээний торгууль ногдуулах
9. Анз төлөх

Хорих болон ажил хөдөлмөр хийлгэхгүйгээр хорих, бүх насаар нь хорих, тодорхой хугацаагаар хорих зэрэг ял нь 1 жилээс 30 хүртэл байдаг. БНСУ -ын ялтны эрх зүйн байдал болон хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг эрүүгийн хууль болон шүүхийн шийдвэр үйцэтгэх тухай хуулиараа нарийвчлан зохицуулсан байдаг. Ерөнхийдөө хорих байгууллага болон хоригдлуудын эрх зүйн байдлыг дараахь хууль тогтоомжуудаар зохицуулдаг. Үүнд:

1. Хууль зүйн яамны тухай хууль
 2. Цагдаагийн байгууллагын тухай хууль
 3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль
 4. Ялын гүйцэтгэл болонялтны эрх зүйн байдлын хууль
 5. Хорих байгууламжийн тухай журам
 6. Харгалзагчийн үзлэг шалгалт хийх журам
 7. Ялын гүйцэтгэл болон ялтны эрх зүйн байдлын хуулийг хүчин төгөлдөр болгох зарлиг
 8. Ялын гүйцэтгэл болон ялтны эрх зүйн байдлын хуулийг хэрэглэх журам
- /2010-05-31/

Ялын гүйцэтгэл болон ялтны эрх зүйн байдлын тухай хуулийн 2 дугаар зүйлд ялтан гэж “хорих, цагдан хорих болон ажил хөдөлмөр хийлгэхгүйгээр хорих, урьдчилан хорин шүүхийн шийдвэр авсан тэрхүү ял нь батлагдсан хүн болон мөнгөн торгуулиа төлж дуусаагүй ажлын байранд ажиллах шийдвэр хүлээн авсан этгээдийг хэлнэ” гэж тодорхойлсон байна.

Шүүгдээж буй этгээд гээж гэмт хэрэгт сэжиглэгдсэн болон шүүгдэгчээр

баривчлагдсан эсвэл цагдан хорих шүүхийн шийдвэр хүлээн авсан этгээдтйг хэлнэ гэжээ.

Тус хуулийн 2 дугаар бүлгийн 11 дүгээр зүйлд зааснаар ялтнуудыг дараах төрлийн хорих байгууламид хорих ял эдлүүлнэ.

1. 19-с дээш насын ялтан: Шорон
2. 19 нас хүрээгүй ялтан: Хүүхдийн хорих
3. Шийдэгдээгүй хоригдол: Саатуулах төв
4. Цаазаар авах ял авсан этгээд: Шорон болон saatuuulaah төвд

Энэ тохиолдолд тодорхой ангиллын стандартыг хууль зүйн яамны дүрэм, журмаар зохицуулна.

Ялтын хөдөлмөр эрхлэлт

Ялын гүйцэтгэл болон ялтын эрх зүйн байдлын хуулийн 4-р бүлэгт ялтын хөдөлмөр эрхлэлтийн талаар зохицуулсан байдаг. Ялтанд ногдуулах ажил нь эрүүл чийрэг амьдралд эргэж очиход туслах зорилгоор ур чадварыг сайжруулах, ажиллах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна. Хорихын дарга ялтанд хийх ажлыг оноохдоо нас, ялын хугацаа, эрүүл мэндийн байдал, ур чадвар, зан ааш, сонирхол, ажил байдлын намтар, ирээдүйн амжиргаа болон ялтын нөхцөл байдлыг харгалзан үзэх ёстой. Ялтан нь өөрт ногдох ажил үүргийг гүйцэтгэх үүрэгтэй. Хорихын дарга нь ажил хөдөлмөр хийлгэхгүйгээр хорих болон урьдчилан хорих шүүхийн шийдвэртэй этгээдэд өргөдөл заасан ажлыг ногдуулж болно. Хорихын дарга нь ялтын эрүүл амьдралд эргэж орход ур чадвараа сайжруулахыг хөхүүлэн дэмжих зорилгоор шаардлагтай гэвэл гадны үйлдвэрт ажилуулах эсвэл хорих байгууламжийн дотор зохион байгуулж гадны үйлдвэрийн ажлыг хийж болно. Энэхүү гадны үйлдвэрийг сонгон авах стандартад холбогдох шаардлагтай зүйлийг хууль зүйн яам шийдвэрлэнэ. Мөн хорихын дарга ялтын ур чадварыг сайжруулах, дээшлүүлэх үүднээс хөдөлмөрийн мэргэжлийн сургуулийг байгуулж болно. Хорихын дарга

ялтын мэргэжлийн сургуульд шаардлагтай гэж үзвэл гадны байгууллага, үйлдвэрт мэргэжлийн сургалтыг хийлгэж болно. Мэргэжлийн сургуульд холбогдох шаардлагтай зүйлийг хууль зүйн яам шийдвэрлэнэ. Ялтан нь амралтын өдөр болон олон нийтийн амралтын өдөр ажиллахгүй. Ялтын дараах тохиолдолд ажлаас чөлөөлнө.

- Гэр бүлийн болон хань ижлийн хамаатан, ойр дотны хүн нас барвал 2 хоног
- Аав ээж болон хань ижлийн нас барсан өдөр 1 өдөр /Хэрэв ялтан ажлаа хийхийг хүсвэл ажллуулж болно./
- Гэмтэл бэртэл, өвчин, ажлаа хийхэд саад болхуйц нөхцөл байдал үүсвэл түүнийг арилгах хүртэл ажлаас чөлөөлж болно.

Ялтын хийсэн ажлын хөдөлмөрийн хөлс нь улсад орно. Хорихын дарга ялтын ажиллах хүсэл сонирхлыг хөгжүүлэх, эрүүл амьдралд эргүүлэн оруулах зорилгоор хууль зүйн яамны сайдын тогтоосны дагуу ажлыг дуусгах, ажлын үр дүн, хүмүүжлийн үзүүлэлт болон бусад нөхцөл байдлыг харгалзан ялтанд ажлын шагнал урамшуулалыг олгож болно.

Ажлын шагнал урамшууллыг суллахад нь өгч болно. Ялтан өөрөө гэр бүлийн амьдралаа тусlamж дэмжих, соён гэгээрэх эрүүл амьдралд эргэн орох зорилгоор шаардлагатай гэвэл суллахын өмнө бүгдийг болон зарим хэсгийг авч болно. Хэрэв ялтан нь ажлын байр мэргэжлийн сургалтын явцад түүний улмаас нас барвал ялтын хөдөлмөрийн шагнал ура мшууллаар авсан мөнгийг өв залгамжлагчид нь өгнө.

Судалгаанаас дүгнэж үзэхэд судалж үзсэн гадаадын улсуудад :

- Хорих байгууллагаас гадуур хөдөлмөр эрхлэх
- Хорих байгууллага дотор буюу суллагдахаас өмнө хөдөлмөр эрхлэх
- Гэрээгээр хөдөлмөр эрхлэх гэх мэтчилэн тусгаж өгсөн нь ажил хийлгэх, хөдөлмөр эрхлэх, эргэн

нийгэмших эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна.

Мөн эрүүгийн хууль тогтоомжоо шинэчлэх, хорих ял эдлүүлэх байгууллагын тухай хууль тогтоомжид өөрчлөлт хийх, хоригдлын ажил хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай баримт бичиг гаргах зэрэг арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд ялтны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажиллах боломж нөхцлийг бий болгох, хөдөлмөрийн үр нөлөөгөөр хүмүүжлийн түвшинг дээшлүүлэх нь ялтны дундаас гарах зөрчил, гэмт хэргийг бууруулах, тэднийг нийгэмд эргэж ороход бэлтгэх, амьдрах зөв арга барилд сургах, ухамсыг нь өөрчлөхөд чухал ач холбогдолтой үйл ажиллагаа болох нь гадаадын аль ч улс орны эрх зүйн зохицуулалтаас харагдаж байна.



С.БАЯСГАЛАН

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ерөнхий жижсүүр, ахмад

**ХОРИХ АНГИЙН ХАРУУЛ
ХАМГААЛАЛТ, ЭЭЛЖИЙН
БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН,
ПРАКТИКИЙН АСУУДАЛ**

Монгол Улс нийгмийн хөгжлийн замаар төрт ёс хууль цаазаа хөгжүүлэн бэхжүүлж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгож, ардчилсан Үндсэн хуулиа тунхагласан тэр цагаас хойш хүний амьдралын бүхэл бүтэн нэгэн мөчлөг улиран өнгөрч, ард түмний маань амьдралын хэвшил, оюун сэтгэлгээнд агуулга чанарын мэдэгдэхүйц өөрчлөлт гарсаар байна. Үүнтэй уялдан хорих ангийн үүрэг зорилгод ч мөн адил чанарын өөрчлөлт гарч эхлэж байна.

Хорих байгууллагын нэг онцлог нь ял шийтгэлийг тодорхой хугацаанд хуулиар тогтоосон тусгай дэглэмтэй хорих анги, гянданд төрийн албадлагаар олон нийтээс тусгаарлан шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялын хугацааг дуусгах хүртэл тодорхой хугацаанд ялтан бүрийг тогтоосон дэглэмд хууль ёсыг хүндэтгэн сахиаг үнэнч шударга иргэн болгон төлөвшүүлэх зорилгыг агуулж байдаг.¹³

Хорих анги бол хүн амьдардаг газар тул тэнд тайван амьдрах орчныг бүрдүүлж болох хэдий ч ингэхийн төлөө харуул

¹³ Ю. Сэргээнжав "Засан хүмүүжүүлэхүй" УБ. 2001 5 дахь тал.